



НИЙСЛЭЛИЙН СОЁЛЫН ТӨВ ӨРГӨӨНИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2020 оны 02 сарын 03 өдөр

Дугаар 1/02

Улаанбаатар хот

Г

Г

Журам батлах тухай

Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Засгийн газрын 2017 оны 243 дугаар тогтоол, “Албан хаагчдын хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм”-ийг үндэслэн ТУШААХ нь:

1. Уран бүтээл техникийн албаны “Албан хаагчдын дагаж мөрдөх хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Журмын биелэлтийн явц, үр дүнг байнга хянаж, хэрэгжилтийн тайланг хагас бүтэн жилээр гаргаж, захирагааны зөвлөлд танилцуулж ажиллахыг албаны дарга /Д.Баянзул/-д даалгасугай.

ЗАХИРАЛ  
Б.БАЙГАЛМАА

Нийслэлийн Соёлын төв өргөөний
захирлын ... оны ... дугаар сарын
03 өдрийн 4/00 дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт

УРАН БҮТЭЭЛ ТЕХНИКИЙН АЛБАНЫ АЛБАН ХААГЧДЫН
ДАГАЖ МӨРДӨХ ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛГААНЫ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Журмын зорилго нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх хууль, тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулж, эрсдэлгүй, аюулгүй, эрүүл ажлын байрны орчинг бүрдүүлэх, ажиллагсдыг эрүүл, аюулгүй орчинд хөдөлмөрлөх эрхий ханггуулж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тохиолдлыг бууруулахад оршино.
2. Албаны албан хаагчид байгууллагын “Албан хаагчдын дагаж мөрдөх хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм”, энэхүү журмыг өдөр тутмын үйл ажиллагаанд даацтадагаж мөрдөж, хэрэгжилтийг хангаж ажиллана.

Хоёр: Сургалт , зааварчилгаа.

1. Уран бүтээл техникийн албаны ажилтнууд болон үйл ажиллагаа зохион байгуулагчдад энэжурмын талаар танилцуулж, зааварчилгаа өгсөн байна. Тэднийг гарч болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх хамгаалах арга ажиллагаанд сургасан байвал зохино.
2. Тайзны ахлах мэргэжилтэн, маркетингийн менежер, найруулагч болон туслах найруулагч нарт тогтолт, сургуулилтын өмнө хөдөлмөрийнаулгүйажиллагааны зааварчилгааг өгч, ажиллагаа бүрт мөрдөж ажиллахыг шаардаж, тусгай тэмдэглэл хөтөлж, баталгаажуулна.
3. Маркетингийн менежер нь хамтран ажиллах гэрээ байгуулж байгаа харилцагч бүрт хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны журмыг тайлбарлан танилцуулж гэрээнд “хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны журам”-ыг мөрдөж ажиллана гэсэн заалтыг тусгасан байна.

Гурав: Албаны дарга нар, туслах найруулагч, тайзны ахлах мэргэжилтэн, нэгжийн ахлагч нарын үүрэг

1. Хөдөлмөрийн хууль, хөдөлмөр хамгааллын дүрэм, заавар, түүнд холбогдох тогтоол шийдвэрийг анги, нэгжүүд хэрхэн биелүүлж байгаад хяналт тавьж, гүйцэтгэлийг шалгаж дүгнэх, удирдлагад тайлагнах,
2. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллах арга техник, үйлдвэрийн ариун цэврийн талаар зохиогдож байгаа ажлын биелэлтийг шалгаж хангаж байх,
3. Байгууллагын аппаратур, хөшиг болон жижиг хэрэглэл, тоног төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл зэргийг тогтмол шалгаж илэрсэн дутагдлыг яаралтай арилгах ажлыг зохион байгуулах,
4. Ашиглалтанд үл нийцэх техник төхөөрөмж, багаж хэрэгслийг ашиглалтаас хасах саналаа байгууллагын тавьж арга хэмжээ авахуулах,
5. Ажиллаж байгаа хүмүүсийн амь насанд аюултай гэж үзсэн тохиолдолд, мөн ажлын байрны хэсэгт шатаж тэсрэх бодис, материал байгаа үед үйл ажиллагааг зогсоож энэ тухай байгууллагын даргад мэдэгдэх,

6. Тоглолтын үед тайз, үзэгчид, гэрэл техникийн болон үйлчилгээний ажилчдын аюулгүйн арга ажиллагааг удирдан зохион байгуулах,
7. Тоног төхөөрөмж, аппаратурын байрлалыг зохицуулан зөв байрлуулах,
8. Жижуурний гэрлийг тогтмол шалгах,
9. Тоглолтод зөвхөн батлагдсан номер, уран бүтээлчдийг оролцуулах ба бусад хүмүүсийг сольж тоглохыг хориглох, бүрэлдэхүүнд өөрчлөлт орох, аппарат хэрэгсэл шинэчлэх, 1 сараас дээш хугацаагаар завсардсан нөхцөлд давтан зааварчилгааг ахлагч нар өгөх,
10. Өвчтэй, эрүүл бус болон бусад шалтгаантай хүмүүсийг сургуулилт, тоглолтонд оруулахгүй байх,
11. Тайз болон техникийн өрөө, агуулах, ажлын байранд харьяалалгүй хүмүүсийг хяналтгүй оруулахгүй байх,
12. Тайлан дээр тайзны ажилтан байхгүй болон хариуцсан дээд албан тушаалтан маркетингийн менежер, туслах найруулагчийн зөвшөөрөлгүйгээр дасгал сургуулилт, зураг авалт хийх, үйл ажиллагаа явуулахгүй байх,
13. Албан хаагчид, ахлагч нар өрөө тасалгаа, ажлын байр, аваарын гарц, аппарат тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, цоож түгжээний найдвартай байдалд онцгой анхаарч ажиллах,
14. Аюулгүй ажиллагааны арга техник, ариун цэврийн дүрэм зөрчсөн хүмүүст арга хэмжээ авах санал удирдлагад тавих, ажиллуулахыг зогсоно.

Дөрөв. Уран бүтээл техникийн албаны ажилтны үүрэг

Албан хаагчид ажлын байрны тодорхойлолтод заасан ажил үүргийг гүйцэтгэхдээ хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангаж, урьдчилан сэргийлж, ямар нэг зөрчил илэрвэл удирдлагад мэдэгдэж, яаралтай арга хэмжээ авч ажиллана.

1. Ажлын байрны цэвэрлэгээ үйлчилгээг өдөр тутам хийхдээ эмж цэгц, цахилгаан, галын аюулгүй байдлыг хангана.
2. Үйлчилгээний ажилчид үзэгчдийн аюулгүй ажиллагаа хангагдаж байгаа эсэхэд, хөгжим хэрэгсэл, техник аппаратур, бусад ажлын хувцас, багаж хэрэгслээ ашиглах, байршуулах зүүж бэхлэхэд болон дасгал сургуулилт, тоглолтын үед өөрийн аюулгүйн байдлыг хангаж, ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, эвдрэл гэмтлийг засч янзална.
3. Эрүүл мэнд сэтгэл зүйн догодолтой байгаа, тоног төхөөрөмж, аппаратур, хөгжим хэрэгсэл, хувцаслалт нь аюулгүй ажиллагааны шаардлагыг хангахгүй ажилтныг ажиллуулах, арга хэмжээ, тоглолтод оруулахгүй байхад анхаарч ажиллах,
4. Ажлын байрны зохион байгуулалт, ариун цэвэр эрүүл ахуйн шаардлагыг зөрчих үйлдэл хийх, согтууруулах ундаа хэрэглэх, тамхи татах, гал гаргах, унтах, ажилд хамааралгүй хүн байлгах, ноцолдох тоглох зэрэг үйлдэл гаргахгүй байх,
5. Арга хэмжээ, тоглолт, сургуулилтын үед ажил үүргээ гүйцэтгэж байхдаа утсаар ярих, тоглох, бусад байдлаар хамтрагчийнхaa анхаарлыг сарниулах аливаа үйлдэл хийхгүй, сахилга баттай хариуцлагатай ажиллаж хэвших,
6. Өөрийн ажлыг аюулгүй ажиллагааны зааварчилгаа аваагүй, хөдөлмөрийн гэрээ байгуулаагүй, ажил удирдагчаас зөвшөөрч томилоогүй гадны хүнээр хийж гүйцэтгүүлэхгүй байх,
7. Өөрийн ажлын байран дахь ашигладаг гэрлийн, дуу дуугаралтын тоног төхөөрөмж пултыг гадны байгууллагын хүнд шилжүүлэхийг хориглоно.
8. Ажлын байран дээр аргагүй тохиолдолд бага насын хүүхэд авчирсан тохиолдолд аюулгүй байдлыг сайтар хангана, хүүхдийг анхаарч үзвэрийн танхимд тоглуулах, шуугилдуулах, ноцолдох, тайз яаман дээр гаргахыг хориглох,

9. Ажлын байранд тоног төхөөрөмжийг зөөвөрлөх, угсрах, буулгах ажлыг болон засварын ажил гүйцэтгэхдээ хөнгөн нимгэн хувцаслахгүй байх, ажлын хувцас хэрэгслийг ашиглалтын дагуу зааврын дагуу өмсөж, хувийн бэлтгэлийг сайтар хангасан байх,
10. Тайз, түүний эргэн тойронд тухайн үйл ажиллагаатай холбоотой ажил гүйцэтгэж байгаа үйлчилгээний болон бусад албан хаагч нар тайзны ажилтантай хамтарч ажиллах,
11. Уран бүтээлээс хамаарч богино хугацаанд микрофон байршуулах тохиолдолд дууны техники болон тайзны ажилтан микрофоны байршил дээр хөгжмийн нэрийг бичин лентээр тэмдэглэгээ хийнэ.
12. Үзвэрийн танхимд болон бусад талбай дахь шатны хэсгээр болгоомжтой зорчих ба түлхэх, яруулах, гүйх, гулсах үйлдэл хийхгүй, өндөр хэсгийн хаалт хамгаалалтыг давж тонгойх, зүүгдэх ирмэг дээр гарч зогсохгүй байх,
13. Тайзны хөшиг бусад даавуун хэрэгслийг солиходоо урьдчилан шалыг арчуулж доор нь том хамгаалалтын бүтээлэг тавьж мөн сольж байгаа хөшигний доор өөрийнх сав уутыг байрлуулж бохирдооос сэргийлж цэвэр цэмцгэр байдлыг хадгалж сольж байх,
14. Техникийн ажилтан нэг бүр өөрийн ашиглаж буй компьютер, хөгжим, аппарат, дуу дуугаралт гэрэл гэрэлтүүлгийн тоног төхөөрөмжийн аюулгүйн байдлыг өдөр тутам шалгаж баталгаажуулсан байна,
15. Сард 1 удаа /сар бүрийн 10-наас 20-ны дотор/ их цэвэрлэгээ хийнэ. Амралтын болон арга хэмжээ сургуулилттай өдөр таарвал дараагийн сул чөлөөтэй ажлын өдрүүдэд нөхөж хийж гүйцэтгэнэ. Үүнд:
 - Тайзны ойр орчмыг цэвэрлэх, 127 болон 128 тоот өрөөнүүдийг цэвэрлэх, декораци, яам, галерей, техникийн давхаруудад иж бүрэн цэвэрлэгээг хийх,
 - Гэрэлтүүлгийн өрөөнд цэвэрлэгээ хийх, лож болон вынусны давхарт цэвэрлэгээ хийх, бүх гэрлүүдийн тоосыг арчиж сорох, штанкетуудын тоосыг арчих, холбоос сигналын утаснуудын тоосыг арчих, трестэрийн өрөөг цэвэрлэх,
 - Дуу дуугаралтын өрөөнд цэвэрлэгээ хийх, тайлан дээр байгаа чанга яригчуудын тоосыг арчих, соруулах, сигналуудын утаснуудын тоос, төгөлдөр хуурыг цэвэрлэх, микрофонуудыг зориулалтын шингэнээр арчиж цэвэрлэх,
 - Техникийн бүрэн бүтэн байдлыг тогтмол шалгаж, алдаа дутагдал, эвдрэл гэмтэл гарсан нөхцөлд удирдлагад мэдэгдэж засаж янзлах арга хэмжээ авах, техникийн үйлчилгээ үзлэг явуулж засварласан тухай бүртгэл хөтөлнө
16. Үйлдвэрлэлийн осол (даатгуулагч нь ажил үүргээ биелүүлэх явцад үйлдвэрлэлийн хүчин зүйлийн үйлчлэлд өртөж эрүүл мэндээр хохирох, амь насаа алдах), мэргэжлээс шалтгаалах өвчний (даатгуулагч хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад үйлдвэрлэлийн сөрөг хүчин зүйлийн нөлөөллөөс шалтгаалсан өвчин) даатгал, гэнэтийн ослын даатгалд даатгуулж тэтгэвэр тэтгэмж авах нөхцлийг бүрдүүлсэн байх,

Тав. Ажлын байрны аюулгүй байдлыг хангах

Албан хаагчид нь хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны арга барилыг эзэмшиж, болзошгүй аюул ослоос өөрийгөө хамгаалах ур чадвартай байна.

1. Хурал арга хэмжээ, тоглолт, сургуулилтын үед хөгжим хэрэгсэл, техник аппаратурыг бэлдэх, байрлуулах, буулгах зэрэг ажлуудыг гүйцэтгэгч ажилтнууд нь аюулгүй байдлыг хангаж ажиллана.
2. Аппарат, Гэрэл техник хэрэгслийг өргөж буулгах үед доор нь хүмүүс зогсохыг хориглоно.

3. Эргэж хөдөлдөг гэрэл өлгөх, холбож байрлуулдаг аппарат хэрэгслийн бэхэлгээг тайз, гэрэл, дуу шуумны ажилтнууд хийж гүйцэтгэх ба тэд доргилт ачаалал, бусад хүчин зүйлүүдийг нарийн тооцож, тусгасан байвал зохино.
4. Ажлын багаж, хувцас, хэрэгсэл зэргийн цэвэрлэгээ үйлчилгээнд шатах шингэн, ашиглахгүй байх зөвхөн зөвшөөрөгдсөн зориулалтын бодисыг хэрэглэнэ.
5. Чийгтэй нойтон шалан дээр алхах, бэлтгэл сургуулилт хийх, тоног төхөөрөмж, цахилгаан хэрэгслийг байршуулж болохгүй.
6. Ус халаагч, богино долгионы зуух ажлын байранд ашиглаж байгаа бол аюулгүй байдлыг хангаж цахилгааны гэмтэл, осол гарах нөхцлийг бүрдүүлж болохгүй, ашиглаагүй тохиолдолд залгуураас салгасан байна. Нойтон чийгтэй гараар цахилгааны утас, унтраалга, залгуурт хүрч болохгүй.
7. Зөөврийн цахилгаан хэрэгсэл ашиглахдаа хүчдэл байгаа эсэх, газардуулга, тусгаарлагч байгааг магадлан шалгасан байна.
8. Тайзны хөшиг бусад даавуун хэрэгсэл нь тоосжилтгүй шатахаас сэргийлэгдсэн байна. Дулаан чийгний хяналттай, болзошгүй гамшгаас сэргийлэгдсэн стандарт хангасан талбайд хадгална
9. Техник хэрэгслийн эд ангиуд нь бүрэн аюулгүй ажиллагааны шаардлага хангсан байхаас гадна хамгаалах элемент /тросс, штанг/-ийг зэвэрдэггүй ган буюу түүнээс илүү металлаар хийж зэврэлтээс хамгаалах бүрхүүл хэрэглэнэ. Тrossын даацыг шалгахдаа ачааллыг 70% ихэсгэн тооцож сонгож авна. Олс нь тусгай зориулалтын уулынхан болон шүхэрчид хэрэглэдэг болон түүнээс сайн чанарынх байвал зохино.
10. Техник хэрэгслийн эд ангийн цахилгаан ба гагнуурыг зөвхөн мэргэжлийн гагнуурчнаар гүйцэтгүүлнэ. Тухайн аппарат хэрэгслийн техникийн пасспортанд нийлүүлэгчийн нэр болон ажил биечлэн гүйцэтгэгч нарын мэдээлэл, гагнуурчны мэдээлэл, тэдгээрт ажиллах эрх олгосон байгууллагыг заавал тэмдэглэнэ. Онц чухал эд ангийг гагнаж засварлан торгоох төдий үйл ажиллагаатайгаар ашиглаж болохгүй, зориулалтын бус эд ангийг сольж хэрэглэхийг хориглоно.
11. Техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг зөвхөн зориулалтын талбайд нь стандартын дагуу бэхэлж байршуулсан байх ба техникийн албаны ажилтны хяналтгүйгээр нэмэлт төхөөрөмж байршуулах, цэвэрлэгээ үйлчилгээ хийх, салгаж угсрах, бусад хэрэгслийг байршуулж ашиглахыг хориглоно.
12. Цахилгаан тоног төхөөрөмжийн тэжээлийн тусгай зориулалтын шийднээс авах ба шийдний гадна талд хамгаалалт хийсэн байна. Үйл ажиллагааны явцад цахилгаан тоног төхөөрөмжүүдэд ямар нэгэн гэмтэл илэрвэл цахилгаан тэжээл, усан хангамж зэргийг тасалж цахилгаанчинд мэдэгдэж яаралтай арга хэмжээ авна.
13. Ажил гүйцэтгэхдээ зөвхөн зөвшөөрөгдсөн зам гарцын дагуу явж гүйцэтгэх ба зам гарц, аваарын гарцыг тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, түүхий эд, хайрцаг, сав суулга гэх мэт зүйлүүдээр хааж таглаж болохгүй.
14. Техникийн албаны ажилтан нь өндөрт хамгаалалтын бүс, олсыг заавал зүүж ажиллана. Олс хамгаалалтын бүсний гогцоо арап нь бүсэндээ болон таазанд найдвартай бэхэлгээтэй байх ба түүний хяналтыг тогтмол хийсэн байна.
15. Гарын алганы арьсыг өвчлөх тасрахаас мөн аппарат хэрэгслийг алдаж гэмтэхээс сэргийлэн гулгамтгай болон ширүүн аппарат хэрэгсэлтэй ажлын бээлий заавал өмсөнө. Ажлын бээлийгээр тогтмол хангах, ашиглалтанд хяналт тавих ажлыг санхүүгийн томилогдсон ажилтан хяналт тавьж бүртгэж ажиллана.
16. Гэмтэл зөрчилтэй аппарат тоног төхөөрөмж, ажлын талбай зэргийг бусдаас тусгаарлах ба ослын тэмдэглэгээ, плакат тогтоож бусдад хор учруулахаас сэргийлнэ.
17. Гадны байгууллагаас нэмэлт гэрэл тавих нөхцөлд тайз болон гэрлийн ажилтнууд заавал хамт байх ба гэрэл гэрэлтүүлгийн тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг шалгуулж баталгаажуулсан байна. Гэрлийн ил утсыг зориулалтын утас далдлагчаар далдалсан байна.

18. Тайзны жижиг хэрэгсэл, тоглолтын үзүүлэнгүүд, бусад хэрэглэлүүд нь зөвхөн дуураймал эд хэрэгслүүд байна. Хурц ир үзүүртэй төмөр эдлэл, жинхэнэ мэс, гэр ахуйн цахилгаан хэрэгсэл (газ, газан плитка, бүх төрлийн цахилгаан халаагуур ус буцалгагч, телевизор, тоглууллагчууд, гэрэл, гар утас, таблет, компьютер), галт хэрэгслүүдасаагуур, галтай салют, лаа, шүдэнз, бамбар, цэрэг дайны зориулалттай хэрэгслүүд) зэргийг биет болон бодит байдлаар нь ашиглахыг хатуу хориглох ба тайзны жижиг хэрэгслийг байгууллагын дарга, албаны дарга нар, туслах найруулагчийн зөвшөөрсөн материалаар хийж бэлтгэнэ, хэрэглэнэ, хадгална.

Зургаа: Байгууллагын “Албан хаагчдын дагаж мөрдөх хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм”-д тусгагдсан бусад асуудлаар

1. Их танхимд зохион байгуулгадж байгаа тоглолт, арга хэмжээнд оролцож байгаа уран бүтээлчид, үзэгч, үйлчлүүлэгчдийн аюулгүй байдалд Уран бүтээл техникийн, Маркетинг үйлчилгээний албаны албан хаагчид, жижүүр, цахилгаанчин, ээлжийн диспетчер нар хамтран ажиллаж, байнга хяналт тавьж ажиллана.
2. Байгууллагын “Албан хаагчдын дагаж мөрдөх хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм”-ийн 1.2-т заасан нөхцөл байдал үүсвэл удирдлагад яаралтай мэдэгдэж, шуурхай арга хэмжээ авч ажиллана.
3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль, дүрэм, журмыг зөрчсөн ажилтан Хөлөмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, дүрмийг зөрчсөн албан тушаалтыгийлдэлнүгэмтхэргийншинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээнэ.
4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль, дүрэм, журмыг зөрчсөн ажилтан байгууллагад эд хөрөнгийн хохирол учруулсан тохиолдолд хөдөлмөрийн дотоод журмын 4.8 заасан хариуцлага хүлээнэ.

-----Оо-----